Монгол Данжуурын орчуулга нь аливаа нэр томъёо болон үгийн гарал язгуурыг илүүтэй хадгалсан нь илэрхий ажиглагдаж байна. Оноосон нэрийг ихэвчлэн санскритаар буулгасан байх боловч зарим үед монголоор орчуулсан байдаг. Жишээ нь:

Язгуурын таван бурханы нэр:

1. Бирозана /Намбарнанзад/
2. Амогасидди /Дондүв/
3. Ачуваяа /Мижодва/
4. Амидива /Одбогмэд/
5. Раднаасамбава /Ринжүн/ хэмээн санскритаар орчуулжээ.

Мөн Занасадва, Базарсадва, Бодьсадва, Махасадва, Хэрүга, Ямандага, Махадива гэх мэтчилэн бурхад, тэнгэрийн нэрсийг санскритаар буулгасан. Энэ нь утга санааг хагас дутуу илэрхийлэхээс зайлсхийж үгийн язгуурыг хадгалан утгыг төгс илэрхийлэх зарчим болно. Жишээлбэл “Зана” хэмээх нь түвдээр “Иши”, монголчилбол “Бэлгэ билиг” буюу “юмсын шинж чанарыг төгс таних ухаан” гэсэн бүрэн утгаараа ойлгогдож байгаа юм. Гэтэл орчин цагт санскрит уг гарвалыг үл хайхран шууд түвд хэлний “Иши” гэсэн үгнээс “Билиг” хэмээн монголчилсон ажиглагддаг. Энэ нь утга санааг гүйцэт илэрхийлж чадахгүйгээр үл барам гажуудуулах талтай.

Гэхдээ дан санскрит нэр томъёог голчилсон уу гэвэл үгүй. Тухайлбал:

- “Нама сангади” хэмээхийг “Нэрийг үнэхээр өгүүлэхүй”
- “Амрида гүндали” хэмээхийг “Рашаан ойлох”
- “Базарсадва” хэмээхийг “Очирсадва”, “Очирт сэтгэлт”
- “Занасадва” хэмээхийг “Бэлгэ билгийн садва”, “Бэлгэ билгийн сэтгэлт” гэх мэт өгүүлбэр зүй, утга агуулгад нийцүүлэн дан санскритаар, зарим хэсэгт монголоор, зарим үед санскрит монгол хосолсон байдлаар орчуулж аль болох махчилсан нэг хэв загварт баригдахаас зайлсхийж уран тансаг сонгодог хэлбэрийг баримталсан нь үе үест нь таацуулж номын утга чанарыг ойлгуулахыг эрмэлзэхийн сацуу орчуулагч нарын мэдлэг чадварыг илэрхийлсэн хэрэг бизээ.

Хоёр. Утгын оноч үгийн баялагийг чухалчилсан

Монгол Данжуурыг хөрвүүлэх явцад ажиглахад тухайн утга санааг илэрхийлэхдээ толгой холбох, илүү дутуу, чамин үг хэрэглэхээс татгалзаж утгыг нь ухах, санааг нь сэтгэх үг хэллэгүүдийг сонгон орчуулахыг чухалчилсан байна. Жишээ дурдвал:

Монгол Данжуур 1-р боть Магтаалын чуулган, "Ялангуяа хэтэрхий магтаал"-аас:

“Хамаг Түүнчлэн ирэгсдэд мөргөмү

Би бээр бус багшийг шүтээд

Ялж төгссөн чамаас аврал эрмүй

Тэр юуны тул хэмээвээс

Та нь гэм үгүй болоод эрдэм төгөлдөр”...

...Махадива хилэгнээд нэгэн сумаар

Гурван давхар балгасыг түлэв хэмээн алдаршив

Чиний бэлгэ билгийн их сумаар

Хилэнгийн чухам сэтгэлийг магад түлэв...

...Чамайг хэн ч айлгаж ядмуй

Хэнд ч үл хөнөөгчийн тул

Гагцхүү чи хэмээвээс мэсийг үл баримуй

Тиймийн тул амьтнуудаас хэтэрхий буй...

Энэ ном нь Хиндү шашинтан Тоозүндүвжай хэмээх уг номыг зохиогч өөрийн билиг оюунаар Бурхан багш болон түүний сургаалыг шинжлэх судалж үнэн зөв зам мөр болохыг таньж өөрийн багш нар, шашнаас татгалзан Бурхан багшийн сургаалыг баримтлан Бурханы шашинтан болсон тухай өгүүлдэг юм.

Эхний хэсэг эрдэм мэдлэгтэй зөв багшийг шүтэж үнэн зөв мөрийг эрхэмлэх тухай, удаах хэсэгт бусад өөр хоорондоо уур хилэн мэсээр тэмцэлдэж байхад төгс гэгээрсэн Бурхан багш билиг оюунаар уур, шунал тачаалыг уг мөргүй болтол арилгасан тухай өгүүлээд тиймээс та бусдаас хэтэрхий илүү гэсэн санааг орчуулагч учир шалтгаанд үндэслэнтовч тодорхой эрэмбэ дараалалтай чадамгай илэрхийлсэн байна. Дээр дурдсан мөрүүдэд илүү дутуу үг нэгээхэн үгүй, "бус, болоод, чухам" гэсэн холбоос зөөлөн үгнүүдийг хэрэглэснээр утга санаа оночтой тодорхой илэрч байна. Ер нь Ганжуур Данжуурын орчуулгад "мөнхүү, чухам" гэх мэт утга тодотгох үгнүүд ихээр гардаг. Үргэлжлэл нь мөн энэ адил буй.

Монгол Данжуур төдийгүй Ганжуурын хувьд ч сонгодог монгол хэлний үг хэллэгээр нэн баян юм. Үүнээс дурдвал,

Түвд	Монгол
• Ифᠰ-ffOP-ь	ноцог /тулга/
• үU-zhЭмь	үрэвгэл /үрүүл/
• өff¼-өffOP-ь	ариун сүрчил /23х/
• ¾Ю-GЭ-Mгһь	гинжир, барилдуулах
• z¼-ᠰь	чанар /тэмдэг/
• ᠰYIG-!»ф¼-үе-qь	нүд жирвэгдэх /зурвас харах/
• үЛ-zБфЕь	амсуур, /балин/
• f-ᠰ¾ь	танхай, үтэл, /эгэл/
• dфG-Gп-qь	томъёологчин /атгагч/ 44х
• өwф-zь	улирах /юүлэх/ 60х
• ZᠰE-EIO-᠋᠋P-zь	оюундаа амсах, бясалган сэтгэх
• 3tP-zь	архины бачим
• өhЭ-,пh	нийлдэх /хуран үйлдэх/
• T-Tфь	зурхиралдах /шуугих/

• zNYPEь	ханхалзах, босгох
• zBP- ³ / ₄ ь	харьдсан мөр, хошного
• Zп-z ¹ / ₄ ь	ухаглан, дотуурлан
• z3%опэ-рь	эрэлхэх /хөөрөмших/
• GZЭG-ь	байгаль /хулс/
• Gba ³ / ₄ -мь	сүрчих, буригруулах /арцыг/
• ±э-Qь	хувь, /татлал/
• өEЫ ³ / ₄ -зь	ойлогч /үелэх, эрчлэх/
• өEЫ ³ / ₄ -зь	туналзсан /эрчилсэн/
• ZэE- ³ / ₄ пмь	жинлэн, цэгнэн сонсох
• эPфm-уфһь	гэсгээл /ил явдал/ хатуу үйл
• zdGE-рь	сорих /шинжлэх, ажиглах/
• мь	сөль /цаботийн 443/
• үeG-рь	хулгай гээг, /ар шил/
• z-Pмь	оронго /амьтан/
• Eh-hЭ-GEфһь	зорин эвдэх /басамжлах/
• өhЭm-q-ь	бахархах /зорих/
• ЗоP-Eпһь	үрэх /үзэгдэл түгэх/
• Vфэ-@Эмь	товтолгох /хулгай/
• »Ыh-hЭ-өфP-ь	тааламжит /сэтгэлд зохист/
• !D ¹ / ₄ -D-һь	наймаалж /мэлхий/
• @m-@ЫP-Тмь	шивэр шугуй /ой/
• hфGE-рь	үтгэргэх /сэжиг/
• ¹ / ₄ Ы-3+пGEь	гургуул, өрөвтас
• Gф-өwP.ь	дэгжил, хутаг
• H!пm-hЭ-өEЫ ³ / ₄ ь	дээшид өрмөглөн /босгох/
• FЫ ³ / ₄ ь	манамж /сонжгууртай байх/
• Eфэ-ZЫ-эпһь	түүдгэрэл /сэжиг, эргэлзээ/

Энэ мэт олон зуун үгийг дурдаж болох авч т бүхэнд сонирхуулах үүднээс цөөн үгийг дурдлаа.

Өгүүлж үл барах далай их ухааны сангаас өчүүхэн төдий нэгнийг чадан ядан өгүүллээ. Эцэст нь дүгнэн өгүүлбэл:

1. Ер хэн юу мэдэхийг хүснэм тэд Монгол Ганжуур, Данжуурыг сөхөж үзүүштэй юм.
2. Орчуулгын онол арга зүй, уламжлал, зарчмыг боловсронгуй болгоход өвөг дээдсийн маань өвлүүлсэн энэ их эх сурвалжууд нэгэн чиг болох нь дамжиггүй.
3. Монгол хэмээн бахархахын нууц тарни болсон сонгодог монгол хэлний далай их үгсийн санг хадгалалж буй Монгол Ганжуур Данжуурыг судалж ирээдүй хойчдоо өвлүүлэх нь зүй ёсны хэрэг болно.

Руни бичгийн дурсгал дахь хэлцийн орчуулга

Н.Гэрэлмаа /МУИС, ГХСС/

Товч агуулга: Эртний түрэг угсаатанд холбогдох руни бичгийн сонгодог дурсгалууд нь дан гагц түүхийн сурвалж бус уран зохиолын найруулгын өнгө аястай, яруу найргийн мөр, бадаг, тогтвортой хэлц хэллэгийг өөртөө багтаасан өвөрмөц найруулгаар зохиогдсон учир бусад хад чулуу, гэрэлт хөшөөний бичээсээс эрс ялгаатай юм. Түүхэн үнэн хэрэг явдлыг ийнхүү уран сайханаар үзүүлэх уламжлал нийт нүүдэлчин угсаатны дунд түгээмэл байсан аж. Уул дурсгалд тэмдэглэгдэн үлдсэн эртний түрэг угсаатны хэл-соёлын нэгэн илрэл болсон зарим хэлц хэллэгийг монгол хэлнээ хэрхэн орчуулсан байдал хийгээд утга дүйх хэлцээр оноон орчуулах боломжийг эрэлхийлсэн болно.

Түлхүүр үг: руни бичиг, сонгодог дурсгал, хэлцийн орчуулга

Монгол нутгаас олдсон эртний түрэг угсаатанд холбогдох руни бичгийн дурсгалууд нь хэл-түүх соёлын чухаг баримт болох бөгөөд агуулга, хэмжээний хувьд харилцан адилгүй байгаа билээ. Руни бичгийн сонгодог дурсгал хэмээн нэрлэж заншсан Келтигин, Билгэ хаан, Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийг Түрэгийн ард түмний эв нэгдлийг эрхэмлэн өөрийн хүчирхэг төр улсыг байгуулсан түүхэн гавьяа зүтгэлийг хойч үедээ алдаршуулах зорилгоор сийлэн үлдээсэн байдаг. Дээрхи дурсгалуудад түүхэн хэрэг явдлыг ерийн тоочин өгүүлэх бус уран сайхны хэл найруулгын аргаар зохион бичсэн тул зөвхөн түүхэн дурсгал бус эртний түрэгийн хэл-уран зохиолын томоохон баримт, эх хэрэглэгдэхүүн болж байна.

Руни бичгийг анх тайлан уншсан түүхийг сөхөн үзвэл 1889 онд Н.М.Ядринцевийн удирдсан Оросын газарзүйн нийгэмлэгийн Дорнод Сибирийн салбарын шинжилгээний анги Монгол нутагт ирж ажиллахдаа Орхоны хөндийгөөс Келтигин, Билгэ хааны гэрэлт хөшөө бүхий цогцолбор дурсгалыг олж илрүүлэн дэлхий дахинд мэдээлсэн байна⁶⁸. Харин 1893 онд Копенхагений их сургуулийн профессор В.Томсен “нууц, тайлагдашгүй” хэмээх руни бичгийг унших түлхүүр цагаан толгойг олж тогтоосноор уул бичээсүүдийн судалгаа эхэлсэн хэмээн үзэж болно. Өнөө уншиж тайлсаны 120 жилийн ой тохиож буй энэ хугацаанд эдгээр гэрэлт хөшөөний бичээсийг

⁶⁸ Н.М.Ядринцев, Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд.Географического Общества, -Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892; Н.М.Ядринцев, Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангае, - Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892, стр. 27-40; Н.М.Ядринцев, Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891 году, -Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр. 1-54

герман, орос, франц, мажар, япон, солонгос, монгол, англи гэх мэт хэлээр орчуулсан буй.

Орчуулгад ихээхэн анхаарвал зохих зүйлсийн нэг бол тухайн хэлт үндэстний соёл, зан заншил, шашин шүтлэг, ертөнцийг үзэх үзлийн нэгэн тусгал болсон тогтвортой хэллэгийн орчуулга билээ. Бид энэхүү судалгаандаа сонгодог гурван дурсгалын хэл найруулгад чимэг болгон оруулсан хэлц, хэллэгийг монгол хэлнээ хэрхэн “идээшүүлэн” буулгаж болох талаар саналаа нэмэрлэхийг зорилоо. Үүний тул даархи мэт гурван зүйл болгон авч үзэв.

1. Өвөрмөц хэлцийн орчуулга:

kızı qaşı yablaq boltaçı tip saqıntım [Келтигин, Хойт тал. 11]

Үгчилсэн орчуулга: нүд хөмсөг нь дорой болох мэт санав би.

Утга дүйлгэсэн орчуулга: ...зовхи нь буух мэт санав би.

Б.Базылхан: ...нүд хөмсөг нь бүлтийх вий гэж санав.

Л.Болд: ... нүд нь бөлцийн хавдаж зовхи нь буусан шиг санагдав.

Тайлбар: Бичээст гарах хам сэдвийн хүрээнд авч үзвэл Билгэ хаан дүү Келтигинийг нас барахад эмгэнэн гашуудаж хэлсэн үгэндээ “... eki şad ulayu iniуьгьньм, оуланım, beglerim, bodunum kızı qaşı yablaq boltaçı tip saqıntım - ...хоёр шад тэргүүтэй ах дүүс, үр ач, ноёд, ард түмэн минь зовхи нь буух мэт санав би” хэмээжээ. Өөрөөр хэлбэл Келтигинийг үгүй болоход ах дүү, ард түмэн нь цөм уй гашууд автсаныг Билгэ хааны өгүүлж байгаагаар ийн бичжээ.

uda basdımız [Келтигин, зүүн тал. 35, 37]

Үгчилсэн орчуулга: ... нойронд дарав бид.

Утга дүйлгэсэн орчуулга: ... гэнэдүүлэн дарав бид.

Б.Базылхан: ... нойр дээр нь дарав бид.

Л.Болд: ... унтаж байхад нь довтлон орж даран сөнөөв.

Тайлбар: Энэхүү хэлцийн бүтцэд байх uda- гэх үгийг u-(нойр хэмээх нэр үг) + da(оршихын тийн ялгалын нөхцөл) болох бөгөөд энд ямар нэг биед хамаатуулах нөхцөл аваагүй байна. Иймээс хойноо авсан үйл үгтэй утгын хувьд нэгдэн нэгэн бүхэл утга санаа илтгэж байгаа болно.

teңri түрьсinte tutup уьгерь күтьрмиш еринч [Келтигин, зүүн тал. 11]

Үгчилсэн орчуулга: тэнгэр дээрээс нь барьж дээшээ аваачсан бөлгөө.

Утга дүйлгэсэн орчуулга: тэнгэр ивээж тэргүүнд залсан билээ.

Б.Базылхан: тэнгэр дээр шиг бишрэн шүтэж өргөмжилсөн билээ.

Л.Болд: тэнгэр зулайгаас нь өргөн дэвшүүлэв.

Тайлбар: Эл хэсэгт бидний үзэж байгаагаар “tүрьсinte tut-” буюу “дээрээс нь барих”, “уьгерь күтьр-” буюу “дээшээ аваачих” гэсэн хоёр өвөрмөц хэлц байна. Хам сэдэвт “qanım ilteriş qayanıу цгьм ilbilge qatunuу teңri түрьсinte tutup уьгерь күтьрмиш еринч

– хан эцэг Илтериш хааныг, эх Илбилгэ хатныг тэнгэр ивээж тэргүүнд залсан билээ” хэмээн гарч буй. “Дээр тэнгэр, Түрэгийн ариун дагшин газар ус түрэг түмнийг битгий үгүй болоосой” хэмээн тэргүүнд нь хан эцэг, хатан эхийг залсан болохыг энэхүү хэлцээр гаргажээ.

izre ašsız tašra tonsuz [Көлтигин, зүүн тал. 26]

Үгчилсэн орчуулга: дотроо хоолгүй, гаднаа хувцасгүй

Утга дүйлгэсэн орчуулга: явган нүцгэн

Б.Базылхан: дотроо хоолгүй, гаднаа дээлгүй

Л.Болд: амандаа идэх хоолгүй, мөрөндөө өмсөх дээлгүй\ дотроо хоолгүй, гаднаа дээлгүй

kergek⁶⁹ bolmiş [Көлтигин, зүүн тал. 4, 30, хойт тал.10]

Үгчилсэн орчуулга: хэрэг болжээ.

Утга дүйлгэсэн орчуулга: Таалал төгсөв, насан эцэслэв, өөд болов.

Б.Базылхан: таалал төгссөн юм.

Л.Болд: насан эцэслэв.

Тайлбар: Бичээст тохиолдох хэлцийн давтамжаас үзэхэд энэхүү хэлцийг “үхэх” гэдгийн хүндэтгэсэн найруулгад хэрэглэж байгаа нь тодорхой байна. Түрэг улсын цэргийн жанжин Көлтигинийг нас барсаныг [тэнгэрт] “хэрэг болов” хэмээн өгүүлж байгаа нь эртний түрэгүүдийн тэнгэр шүтлэгтэй холбоотой үүссэн хэлц болов уу.

usin buntutu yurtda yatu qalur erti [Тоньюкук, зүүн тал. 2]

Үгчилсэн орчуулга: нойроо хаяж хээр хэвтэн үлдэж билээ.

Утга дүйлгэсэн орчуулга: нойроо умартан хээрээр гэр, хэцээр дэр хийж байв.

Л.Болд: Усун бунтатугийн нутагт суурьшин [тэндээ амьдарч] үлдэх байсан юм.

А.Амар: Үшин Будатуг хаав.

Тайлбар: Хэлцийн бүтцэд байх эхний хоёр үгийг судлаачид газрын нэр мэтээр ухаарсан байна. Гэвч “buntut-зугатаалгах” гэх үгийн утгаас үүдэн бид “нойроо хаях, гээх” гэж орчуулах нь зүйтэй хэмээн үзлээ. Харин “yurtda yatu qal-хээр хэвтэж үлдэх” гэсэн хэлцийг “хээрээр гэр хийх” –тэй утга дүйлгэв.

adaq gamšatdı [Көлтигин, хойт тал. 7]

Үгчилсэн орчуулга: хөл гуйвав, салганан чичрэв.

Утга дүйлгэсэн орчуулга: хүч мөхөстөв, доройтов

Б.Базылхан: тамирдав.

Л.Болд: туйлдан ядрав.

⁶⁹ Энэхүү үгийг эртний түрэг хэлний толь бичигт “хэрэгтэй, шаардлагатай” хэмээсэн утгатай болохыг тэмдэглэжээ.

ot sub qilmadım [Көлтигин, зүүн тал. 27]

Үгчилсэн орчуулга: гал ус болгосонгүй би.

Утга дүйлгэсэн орчуулга: дайсан болгосонгүй би.

Б.Базылхан: гал усанд автуулсангүй би.

Л.Болд: гал ус болгон харшилдуулсангүй.

2. Хэвшмэл хэлцийн орчуулга:

ud tengri aysar kiši oylı qop ılgeli tırımıř [Көлтигин, хойт тал. 10]

Үгчилсэн орчуулга: цагийн тэнгэр хэлбэл хүний хүү цөм үхэхээр төржээ.

Утга дүйлгэсэн орчуулга: “Цагийн” тэнгэр зарлиглавал хүний хүү цөм үхэхээр заяагджээ.

Б.Базылхан: тэнгэр бүтээх үед хүний хөвүүн олноор үхэх гэж төрсөн юм.

Л.Болд: тэнгэр бурханы таалсан цаг ёсоор хүний хүү бүгд үхэхээр төрдөг.

Тайлбар: Хэлцийн бүтцэд буй “aysar” гэх үгийг үгийн бүтцээр задлан үзвэл ау- (хэлэх, өгүүлэх гэсэн утгатай үйл үндэс) + sar(болзох төлөвийн нөхцөл) болно. Судлаачид монгол хэлний “айлтгах, айлдах” мөн түүнчлэн “ай” гэх аялга үгсийг нэг гаралтай хэмээн үзэж буйгаас харахад уул үгийн хүндэтгэх найруулгын утга монгол хэлнээ хадгалагдан үлдсэн нь тодорхой байна.

turuq buqalı semiz buqalı ıraqda bilser

semiz buqa turuq buqa teyin bilmez ermiř [Тоньюкук, баруун тал. 5.6]

Үгчилсэн орчуулга: туранхай бух тарган бухыг холоос мэдвэл тарган туранхай бух гэж мэдэхгүй бөлгөө.

Утга дүйлгэсэн орчуулга: бухыг холоос хараад тарган туранхайг ялгахад бэрх бөлгөө.

Л.Болд: туранхай бухтай, тарган бухтай [үхэр сүрэг] алсад бэлчиж байвал [хүмүүс] энэ нь тарган бух, тэр нь туранхай бух гэж ялгаж мэдэхгүй.

А.Амар: холоос тарган буга туранхай буга хоёрын тарган туранхайг ялгахад бэрх хэмээлээ би.

Тайлбар: Түрэгийн мэргэн сайд Тоньюкукийн хэлсэн энэ үг “...Түрэг түмнийг хураан нэгтгэсний дараа шударга, үнэнч хааныг олж хаан ширээнд зална” гэдэг бол “бухыг холоос хараад тарган туранхайг ялгахад бэрх” байгаатай адил юм гэсэн утга агуулгатай хэлц юм.

yuyqa erkli topulıyalı ućuz ermiř

yinćgd erklıg ızgeli ućuz

yuyqa qalıń bolsar topulıuluq alp ermiř

yinćgd yoyun bolsar ızgılyk alp ermiř [Тоньюкук, өмнө тал. 6]

Үгчилсэн орчуулга: нимгэн байхад нугалахад хялбар бөлгөө, нарийн байхад хугалахад хялбар бөлгөө. Нимгэн нь зузаан болвол нугалах хэцүү бөлгөө, нарийн нь бүдүүн болвол хугалах хэцүү бөлгөө.

Л.Болд: [ямар нэг юмыг] нимгэн [ахуйд] нугалахад хялбар, нарийн [ахуйд] хугалахад амар, нимгэн юм том болоход [түүнийг] нугалахад баатар [зориг] хэрэгтэй, нарийн юм зузаан болбол [түүнийг] урахад баатар [зориг] хэрэгтэй.

А.Амар: ямар нэг юмыг зөөлөн ахуй доор түүнийг нугалах хялбар. Нимгэн ахуй доор түүнийг урах хялбар. Хэрэв зөөлөн юм хатуу болохул түүнийг нугалахад баатар зориг хэрэгтэй. Нимгэн юм зузаан болох ахул түүнийг урахад баатар зориг хэрэгтэй.

Тайлбар: монгол орчуулгаас харахад утгын хувьд зөрүү байхгүй хэдий ч “alp” буюу баатар гэх үгийн утгаас үүдэн гагц энэ үгийг “баатар зориг хэрэгтэй” гэж буулгасан байна. Бидний санахад энэ үгийн бичээст тохиолдох давтамжаас үзэхэд “эрэлхэг, баатар, дийлдэшгүй” гэх тэмдэг нэрийн үүргээр гарч байгаа тул “хэцүү, бэрх” гэсэн утгаар ойлгох боломжтой ажээ.

3. Зарим хэллэгийн орчуулга:

kūzde yaš kelser tūda kūngyld sūyt kelser yanturu saqintim [Көлтигин, Хойт тал 11]

Үгчилсэн орчуулга: нүдэнд нулимс ирвэл барьж зүрхэнд гуниг ирвэл буцааж санав би
Утга дүйлгэсэн орчуулга: нулимсаа барьж зүрхээ чангалан...

Б.Базылхан: нүдэндээ нулимс гүйлгэнэн ирвэл бие сэтгэл хөдлөн уйлахад хүрвэл дахин санав би.

Л.Болд: нүдэнд хурсан нулимсаа хүчээр тогтоон, зүрхэнд хурсан уй гунигаа хүчээр даран сарниаж бие сэтгэлээ ихэд барив.

Тайлбар: Энэхүү хэллэг дүү Көлтигинийг нас барахад Билгэ хааны хэлсэн гашуудлын үгэнд гарч буй. Утга агуулгын хувьд “тэнгэр зарлиглавал” “хүн төрсөний эцэст үхдэг жамтай” тул “сэтгэлээ барьж зүрхээ чангалав би” хэмээх мэт болно.

цльgi yurtда yolта yatu qalta᠘i ertigiz [Көлтигин, хойт тал. 9]

Үгчилсэн орчуулга: үхэгсэд нь хөдөө, замд хэвтэж үлдэх бөлгөө, бид)

Утга дүйлгэсэн орчуулга: үхэж үрэгдсэн нь хээр хөдөө, зам зуур хаягдах\орхигдох болно.

Б.Базылхан: үхдэл нь буйранд, замдаа хаягдах болуузай.

Л.Болд: үхэгсэд нь нутагтаа, зам зууртаа хэвтэн үлдэх байлаа.

Тайлбар: Хэллэгт байх “yatu qal-хэвтэж үлдэх” гэх хэлц нь “хаягдах, орхигдох” гэх нэгэн утга илтгэж байгаа хэмээн санана.

ьze tengri basmasar asra yer telinmeser [Көлтигин, зүүн тал. 22]

Үгчилсэн орчуулга: дээд тэнгэр дарахгүй бол, доор газар цоорохгүй бол

Утга дүйлгэсэн орчуулга: Тэнгэр нурж газар цөмрөхгүй бол...

Б.Базылхан: дээрээ тэнгэр дарахгүй бол, дороо газар тэлэхгүй бол

Л.Болд: дээр тэнгэр нураагүй юм бол, доор газар цөмрөхгүй юм бол...

otča borča kelti [Көлтигин, зүүн тал. 37]

Үгчилсэн орчуулга: гал мэт шуурга мэт ирлээ.

Утга дүйлгэсэн орчуулга: гал мэт, шуурга мэт дайран ирлээ.

Б.Базылхан: Гал шиг улангасан, дарс шиг эрслэн ирлээ.

Л.Болд: гал шиг дүрэлзэн, дарс шиг шуугин ирэв.

Тайлбар: Эртний түрэг хэлний толь бичигт “bor” гэх үгийг “шуурга, цасан шуурга, хар шуурга” хэмээсэн утгатай болохыг тэмдэглэсэн байдаг.[Наделяев В.М...,1969, стр.113] Орчин цагийн түрк хэлэнд их шуургыг “bogan” гэж буй. Харин монгол хэлэнд энэхүү үг эрт үедээ мөн адил “салхи, шуурга” гэсэн утгатай⁷⁰ байсан бол өнөө “хур бороо” болон утга өөрчлөгдсөн байна.

Энэ мэтчилэн руни бичгийн дурсгалд гарах хэлц хэллэгийг монгол хэлнээ дүйлгэн орчуулахад 1. Үгчилсэн орчуулгаас үүдэн хэлцийн нэгдмэл утга алдагдаж байгааг, 2. Монгол хэлний бэлэн хэлц, хэллэгээр дүйлгэн орчуулахад түрэг угсаатны соёлын онцлогийг хадгалан үлдсэн хэлний нэгжийг орхигдуулах сөрөг тал ажиглагдаж байгааг дурдах хэрэгтэй.

Резюме

Надписи на памятнике являются не только языковыми и историческими памятниками, а также литературными. В данной надписи были искусно использованы методы художественной литературы как идиом и фраз.

Традиции художественного изложения исторических событий постоянно встречаются у кочевых народов.

И так, автор данной статьи считает что, кроме лингвистического исследования памятника, следует глубоко анализировать со стороны литературы и стилистики.

Ашигласан ном, эх хэрэглэгдэхүүн

Кирилл үсгээрхи:

1. Амар А. Монголын товч түүх, Улаанбаатар, 1989
2. Базылхан Б, Күл-тегиний хөшөөний бичээсийн монгол орчуулга, Хэл зохиол, Том. XVI, fasc. 1-19, Улаанбаатар, 1987, 45-67-р тал.
3. Болд Л, Орхон бичгийн дурсгал III, Улаанбаатар, 2010
4. Болд Л, Орхон бичгийн дурсгал IV, Улаанбаатар, 2011
5. Наделяев В.М..., Древнетюркский словарь. М-Л., 1969
6. Ядринцев Н.М., Отчет экспедиции на Орхон, совершенной в 1889 г. Поручению Восточно-Сибирского Отд.Географического Общества, -Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892

⁷⁰ “Монголын Нууц Товчоон”-ы 108 зүйлд “jamuqa ыгыгын **boro`an** ber bolu`asu boljal-tur qura ber bolu`asu qural-tur bu qojidaya” хэмээн гардаг.

7. Ядринцев Н.М., Предварительный отчет об исследованиях по р.Толе, Орхону и в Южном Хангае, -Сборник трудов Орхонской экспедиции 1, Санкт-Петербург, 1892, стр.

27-40

8. Ядринцев Н.М., Отчет и дневник о путешествии по Орхону и в Южный Хангай в 1891

году, -Сборник трудов Орхонской экспедиции V, Санкт-Петербург, 1901, стр. 1-54
Латин үсгээрхи:

1. Orhun H.N, Eski türk yazıtları, Ankara, 1986

2. Tekin T, Orhon yazıtları, Kältigin, Bilge kağan, Tunyukuk, İstanbul, 2003

3. Tekin T, Tunyukuk yazıtı, İstanbul, 1993

“譯” хэмээх үсгийн гарлын асуудалд

Ш.Эгшиг /МУИС, ГХСС/

Түлхүүр үг: хэлмэрч түшмэл, орчуулга, Ёслолт ном, Хань улсын түүх, ху хэл, шаньюй

Хятад хэлний 译 (ум) хэмээх энэ ханз үсгийн утга бол орчин цагийн хятад хэлний үгийн тольд “орчуулга, орчуулах” гэсэн утгатай гэжээ. Энэ үгийн анхаарал татсан шалтгаан бол хятадын эртний сонгодог зохиолуудын нэг болох “Ёслолт ном”-ын “Вангийн ёс”-ны бөлөгт буй нэгэн хэсэгтэй холбоотой. Тэнд 《禮記 王制》: “五方之民, 言語不通, 嗜欲不同。達其志, 通其欲, 東方曰寄, 南方曰象, 西方曰狄鞮, 北方曰譯。 буюу “таван зүгийн ардын хэл нэвтрэлцэхгүй, дур өөр болой. Зоригт нь хүрч, дурд нь нэвтрэе хэмээгч нь дорно зүгт ‘жи’, өмнө этгээдэд ‘сян’, өрнө зүгт ‘ди ди’, хойд зүгт ‘и’ хэмээгдэх түшмэд бөлгөө.” гэсэн байдаг. Энд өгүүлэн буй хойд зүгийнхэнтэй хэл ул нэвтрэх тэрхүү түшмэд нь ‘и’ буюу хятадаар 譯 (ум) гэсэн үг юм. “Ёслолт ном”-ын доторхи энэ үгийг одоогийн бидний ухаарлаар төв оронд оршин байх хятад угсаатан түүний дөрвөн талд орших харь хэлтнийг нийлүүлээд таван зүг хэмээжээ. Тэд бүгдээр бие биеэсээ ялгаатай өөр өөр хэлтэй тул хоорондоо ойлголцон нэвтрэхэд бэрх хийгээд басхүү зан заншил, дур сонирхол бүгд өөр ажээ. Чингэхдээ “Ёслолт ном” бичигдэх тэр үед тэдгээр харь хэлтнүүдтэй хэл залгах одоогийн бидний хэлмэрч хэмээх бага зэрэгтэй түшмэд байсан бөгөөд дөрвөн зүгийнхээ гадаад улс тус бүрт нь өөр нэртэй хэл нэвтрэх түшмэд байжээ. Тухайлбал, зүүн зүгийн улстай харьцах түшмэлийг ‘жи’, өмнө зүгийн улстай хэл нэвтрэх түшмэлийг ‘сян’, баруун зүгийнхэнтэй хэл нэвтрэх түшмэлийг ‘ди ди’, хойд зүгийнхэнтэй нэвтрэх түшмэлийг ‘и’ гэж нэрлэж байжээ. “Ёслолт ном” бол Кунзын шавь нар хийгээд Байлдаант улс (МЭӨ 475-221-р он)-ын үеийн кунзын сурталтнуудын бүтээсэн сонгодог бүтээл юм. Энэ бүтээл уг нь анх 130 бөлөгтэй байсан нь Хятадын Тан улсыг хүртэл хялбарчлагдан засагдсаар эдүгээ 46 бөлөгтэйгээр уламжлан ирсэн ба үүний дотор “Вангийн ёс” хэмээх нэг бөлөг бий.

Тэгэхээр МЭӨ 4-3-р зууны үед 譯 (ум) хэмээх энэ ханз нь орчуулагч хэлмэрч хийх үндсэн ажилтай түшмэлийн нэрийдэл байжээ. Хятадын Хань улсын түүхэнд (《漢書》) МЭӨ 1-р онд болсон нэгэн үйл явдлын талаархи тэмдэглэлд 哀帝元寿二年 (公元前一年), “匈奴单于来朝, 宴见, 群臣在前”。哀帝的宠臣董贤也参加了宴会。“单于怪 (董) 贤年少, 以口译。上令译报曰: ‘大司马年少, 以大贤居位。’单于乃起拜, 贺汉得贤臣。” буюу “Хань улсын Айди хааны 2-р онд Хүннүгийн Шаньюй Хятадад ирэн хааны зоогон дээр олон түшмэдийн өөдөөс харан суужээ. Айди хааны энхрий түшмэл

(хайртай түшмэл) Дун Шиэн мөн оролцжээ. Хүннүгийн Шаньюй өмнөө буй түшмэлийг насаар тун залуу болохоор нь хэлмэрчээр дамжуулан Хань улсын хаанаас асуухад, Айди хаан мөн хэлмэрчээр дамжуулан, ‘Их түшмэл (цэргийн түшмэл) насаар бага ч их мэргэн хийгээд чадварт нэгэн тул түшмэлийн сууринд таарсан бөлгөө.’ хэмээхэд, Шаньюй суудлаасаа босон Хань улсын мэргэн түшмэлд баяр хүргэн ёсолсон гэжээ.”

Хань улсын түүхэнд тэмдэглэсэн өөр нэгэн баримтад мөн хэлмэрчийн тухай мэдээ байна. “中书谒者令宣持单于使者语，视诸将军、中朝二千石。Хань улсын төрийн ёслолын Шуан гэгч түшмэл Хүннүгийн элчийн хэлсэн үгийг хэлмэрчлэн, бичигт буулган тэмдэглэснээ олон жанжин хийгээд төрийн олон түшмэлийн (2000 түшмэл) өмнө уншиж дуулгажээ. Тэр бичигт “冒顿单于得汉美食好物，谓之恶，单于不来明甚。” “Хүннүгийн хаан Модун шаньюй Хань улсаас бэлэглэж илгээсэн амтат идээг үзээд, эвгүй муухай өмхий юм байна хэмээжээ. Үүнээс ухан үзвэл, Модун шаньюй энд (Хань улсад) ирэхгүй гэсэн хэрэг буй заа” гэжээ.

Хань улсын албан түүхэнд тэмдэглэсэн энэ хоёр баримтад 譯 (ум) гэсэн үг ‘хэлмэрчлэх орчуулах’ утгаар тэмдэглэгдсэн байна. Чингэхдээ эхний баримтад 口譯 буюу ‘хэлмэрчлэх’ гэсэн утгаар байх ба дараагийн жишээнд мөн адил элчийн хэлснийг хэлмэрчлээд, түүнийг нь бичиж буулгасан гэсэн байгаагаас үзэхэд Хань улсын үед энэхүү ханзны утга нь голдуу ‘хэлмэрчлэх’ гэсэн утга илэрхийлж байсан бололтой байна. Тэгэхээр энэ үеэс даруй хоёр гурван зуун жилийн өмнө энэ үг хойд зүгийн харь хэлтний хэл яриаг залгуулах түшмэлийн нэрийдэл байснаа Хань улсын үе болж ирэхэд ‘хэлмэрчлэх’ гэсэн үйл үгийн утгаар хэрэглэгдэх болсон байна. “Ёслолт ном” бичигдэх үед энэхүү хойд зүгийн улстай хэл ул нэвтрэх ‘и’ нэрт түшмэлээс гадна зүүн зүгийн улстай харьцах түшмэлийг ‘жи’, өмнө зүгийн улстай хэл нэвтрэх түшмэлийг ‘сян’, баруун зүгийнхэнтэй хэл нэвтрэх түшмэлийг ‘ди ди’ гэсэн түшмэлүүд мөн ижил тэгш эрхтэйгээр хаан төрийн хэрэгт алба залгуулдаг байсан атал тэдгээр нь орчуулах хэлмэрчлэх гэсэн утгыг гаргахгүй байгааг орчин цагийн хятад хэлний толиос нягтлан үзэхэд хангалттай юм. Үүнээс ургуулан бодвоос, Хятадын түүхэнд Баруун, Зүүн Хань улсын оршин тогтноход хойд зүгийн нүүдэлчдийн нөлөө их байснаас тэдэнтэй харьцах давуу хэрэгцээ шаардлагын улмаас 譯 (ум) гэдэг ханзны хэрэглээ их байгаад энэ нь аажимдаа анхны утгаасаа шилжин ‘хөрвүүлэх, орчуулах’ гэсэн утгаар нь хэрэглэх болжээ. Энэ талаар хятадын судлаачид мөн дурдсан зүйл бий.

Хятадын түүхэнд Хань улсаас өмнө оршин тогтнож байсан Жоу (МЭӨ 1046-МЭӨ256) улсын үед улсын ёслолын алба хариуцсан түшмэлийг (象胥) сянсю гэдэг байсан ажээ. Сянсю нь дөрвөн зүгийн харь улсаас ирэх элч зочдыг угтан авдаг хэлмэрч түшмэл байсан юм. Энэ үгийг Жоу улсын үед л түгээмэл хэрэглэж байгаад, хожим хэрэглээ нь саарч, 譯 хэмээх түшмэлийн нэрэнд сууриа тавьж өгсөн шиг байна.

Зүүн Хань улсын Сю Шень хэмээгчийн зохиосон “Үсгийн тайлбар”⁷¹-т ‘译 үсэг бол дөрвөн зүгийн харийнхны хэлийг дамжуулагч бөлгөө’ (据东汉人许慎《说文解字》: “译”是传四夷之语者。) гэсэн байдаг. Энэ бол Хань улсын үед энэхүү үгийг тайлбарласан нь юм. Мөн Хань улсын түүхэнд ‘Холоос элч ирвээс, есөн зүйлийн аргаар орчуулган хэл нэвтрэх бөлгөө’ (“远国使来, 因九译言语乃通也。”) гэсэн байдаг. ‘Есөн зүйлийн арга’ хэрэглэн гэсэн нь орчуулан хэлмэрчилж болох бүхий л аргыг хэрэглэх гэсэн санаа бөгөөд үүнд хэрэв шууд хэлмэрчлэх хятад хүн эс олдох аваас өөр хэлээр дамжуулан ойлголцох, эсвэл тэрхүү холын улстай хил зэрэгцэн орших ардын дундаас хятад хэл мэддэг хүнийг олж орчуулгах, эсвэл ойр дөрвөн зүгийн хил залгаа орны иргэдээс хэлмэрчлүүлэх зэрэг аль бүхий аргаа хэрэглэнэ гэсэн үг юм.

譯 (ум) хэмээх ханзны утгыг хятад хэлний толь бичгүүдээс шүүж үзвэл дараахь мэт байна.

1. Манжийн Энх-Амгалан хааны зохиолгосон үсгийн толь⁷²-д (康熙字典 Энх-Амгалан хааны зарлигаар 1710 онд эхэлж, 30 гаруй эрдэмтдийн хүчээр 1716 онд хийж дууссан нийт 47035 ханз үсэгтэй толь бичиг) “傳譯四夷之言者” буюу “дөрвөн зүгийн харийнхны үгийг дамжуулан орчуулагч” гэсэн нь дээр өгүүлсэн Зүүн Хань улсын Сюшений тайлсантай бараг адил тайлбар байна.
2. Хятад хэлний үгийн гарлын толь “辭源⁷³”-д 1. 傳譯四夷之言者。見<說文>。謂傳他國之語言文字而達其意也。2. 詁釋經義亦曰譯。<潛夫論考績> 賢人為聖譯。 гэсэн нь нэгдүгээр утга нь Энх-Амгалангийн үсгийн тольд байгаатай утга ижил, хоёрдугаар утга нь судрын утгыг тайлбарлахыг мөн орчуулан хөрвүүлэх гэнэ гэжээ.
3. Хятад хэлний их толь бичиг “中文大辭典⁷⁴”-д хятад хэлний үгийн гарлын тольд буй хоёр утга байгаагийн дээр гурав, дөрөвдүгээр утга нь хятадын нутгийн аялгууны утга болох харах, үзэх ба шилэн сонгох гэсэн утгыг тэмдэглэн оруулжээ.
4. Хятад үгийн далай хэмээх “辭海⁷⁵”-д нэгдүгээр утга нь ‘нэг хэлний үгийг нөгөө хэлний үгээр орчуулан хөрвүүлэхийг хэлнэ. Эрт цагт судрын утгыг тайлбарлахыг мөн хэлдэг байжээ.’ Хоёрдугаар утга нь ‘эрт цагт хойд зүгийн үндэстний хэлийг орчуулагч түшмэлийг нэрлэдэг.’ гэсэн байна.

Хятадын сүүлийн үеийн эрдэмтэн ба дипломатч нарын бичсэн өгүүллүүдэд энэхүү 譯 (ум) үсгийн үүслийн талаар дурдсан зүйл нэлээд их гарчээ. Тухайлбал, БНХАУ байгуулагдсан үеэс ажиллаж байсан зөвлөх дипломат Ма Баофен чөлөөнд

⁷¹許慎撰，徐鉉校定：《說文解字附檢字》，北京：中華書局，2004年

⁷²康熙字典 同文书局原版，光绪十三年丁亥（1887）孟夏印，页1188第18字

⁷³辭源，商务印书馆香港分店，1986，743页

⁷⁴中文大辭典，中國文化大學印行，1990年，第八冊，1150頁，第36856字

⁷⁵辭海，1989年版，上海辭書出版社，第443頁

гарснаас хойш Хятадын шинэ үеийн гадаад харилцаанд холбогдох олон түүхэн баримтат өгүүлэл бичсэн юм. Тэрээр “Эртний орчуулгын ажлыг тандах нь”⁷⁶ өгүүлэлдээ хятадын эрт цагийн хойд зүгийн орчуулгын түшмэлийн нэрийдэл Хятадын Хань улсын үеэс одоогийн ‘орчуулагч, орчуулах’ гэдэг утгандаа бүрэн шилжсэн байна гэсэн юм. Хятадын Ниньбогийн их сургуулийн Хө Айжүнь, Чяо Лулу нарын бичсэн “译 -ээс 翻译-д хүртэл”⁷⁷ гэдэг өгүүлэлд 译 (ум) үсгийн үүсэл нь дээр өгүүлсэнтэй адил хийгээд харин эдүгээ хэрэглэж буй хоёр үет 翻译 (орчин үеийн ‘орчуулах’ гэдэг үг) хэмээх үг болсон нь шашны ном зохиолыг орчуулах үед хамаарч байна. Зүүн Хань улсын үед шашны ном судар орчуулж эхэлсэн бөгөөд Тан улсын үед оргилдоо хүрч, Сүн улсын үеэс хятад хэлээр шашны зохиолыг барлаж эхэлсэн гэдэг. Анхлан 译 (ум) нь хойд зүгийн нүүдэлчидтэй харилцах нь ихсэж, тэдний соёлоос нэвтэрч, танин мэдэх шаардлагын улмаас хэлмэрчлэх, орчуулах ажил нь энэ зүгт илүү төвлөрсөнтэй холбогдон бусад зүгийнхэнтэй харилцах харилцаа нь саарсан зэргээс шалтгаалан зөвхөн энэ үгээр л хэлмэрчлэх, орчуулах түшмэлийн нэрийн хэрэглээ ихэссэнээс бусад ‘жи, сян, диди’ гэсэн үгсийг аажмаар хэрэглэхээ больж, мөнөөх ‘и’ хэмээх үгэнд байраа тавьж өгсөн хэрэг. 译 (ум) нь яваандаа түшмэлийн нэрнээс ‘хэлмэрчлэх’ гэсэн үйл үг болж, тэр нь бас улмаар бичгийн орчуулгыг бас хамаарах болж, цаашлаад бурхны шашин Хятадад дэлгэрснээр шашны ном зохиол орчуулах шаардлагын үүднээс ху хэл⁷⁸ ба самгард хэлнээс хятад хэл рүү орчуулах гэсэн утгыг агуулах болсон байна. Энэ үед шашны зохиол орчуулахад урьдын ‘хэлмэрчлэх, орчуулах’ утгаас гадна шашны судар орчуулах нөр их ажлын явцад орчуулах үйлийг дан ганц 译 (ум) гэдэг үсгээр илэрхийлэх нь хангалтгүй болж, 翻 (fān) хэмээх үйл үгийг давхар хэрэглэж эхэлжээ. Гэхдээ энэ үгийг баттай хэрэглэж заншсан үе нь бүр Тан улсын үед гарсан бичгийн дурсгалаас үзэгддэг байна. Тэгэхээр эндээс гарах нэг гаргалгаа бол монголчуудын өвөг дээдэс бурхны шашны зохиолыг хэдийн өөрийн хэлээр орчуулсан байсан эсвэл бүр туурвисан байсныг хятадын Хань улсын үеэс хятад хэл рүү орчуулж байсан болж таарч байгаа юм.

Эцэст нь дүгнэхэд, монголчууд бид хятадын хэлмэрчлэхүй, орчуулгын түүхэнд тун гүнзгий мөрөө гаргасан ард түмэн ажээ. Хятадын сонгодог зохиол болох “Ёслолт номд” бүхий хятадтай харьцаж байсан дөрвөн зүгийн үндэстэн тус бүртэй хэлмэрчлэх үүрэгтэй түшмэлийн нэрийдлээс эдүгээ зөвхөн хойд зүгийн нүүдэлчдийн хэлээс

⁷⁶ 马保奉, 古代翻译工作浅探 发布日期: 2010- 05- 14, 山东省外事信息网

http://www.sdfao.gov.cn/art/2010/5/14/art_550_1908.html

⁷⁷ 贺爱军, 乔璐璐 “从‘译’到‘翻译’” 宁波大学学报(人文科学版), 第26卷, 第一期, 2013年1月第42页

⁷⁸ Ху хэл нь одоогийн шинжаан, монголын нутагт аж төрж байсан эртний омог үндэстний нийтлэг хэл бөгөөд тухайн үед энэ хэлт ард түмнүүдтэй харилцах нь хань үндэстний гадаад харилцааны түүхэнд чухал суурь эзэлж байсан юм.

хэлмэрчилдэг түшмэлийн нэр нь хэлний түүхэн олон үе шат, шалгуурыг давсаар эдүгээ ‘орчуулах’ гэсэн утга бүхий үгийн аймгийн өөр ай болох үйл үг болж хятад хэлний хамгийн түгээмэл хэрэглэгдэх үг болсон байна.

Номзүй:

1. 葉衡 選註, 《禮記》, 學生國學叢書, 台北市, 台灣商務印書館, 1964. 12.
2. 漢書, 班固著, 中華書局, 顏師古註釋, 全十二冊, 1962. 6.
3. 許慎撰, 徐鉉校定: 《說文解字附檢字》, 北京: 中華書局, 2004 年
4. 康熙字典 同文书局原版, 光绪十三年丁亥 (1887) 孟夏印
5. 辞源, 商务印书馆香港分店, 1986年
6. 中文大辭典, 中國文化大學印行, 1990年
7. 辭海, 1989年版, 上海辭書出版社
8. 马保奉, 古代翻译工作浅探 发布日期: 2010.05.14, 山东省外事信息网

http://www.sdfao.gov.cn/art/2010/5/14/art_550_1908.html

9. 贺爱军, 乔璐璐 “从‘译’到‘翻译’” 宁波大学学报 (人文科学版), 第 26 卷, 第一期, 2013 年 1 月

Summary

In this paper the author focused on origin of chinese character 譯 (ym). Meaning of this character is ‘translate’ and this word was used as official person who responsible for interpreting from north tribes language (Mongolian ancestors’ language).

ОРЧУУЛГЫН ШҮҮМЖ СУДЛАЛ

Орчуулгын онол практикийн асуудалд Б.Явуухулангийн

“Би хаана төрөө вэ?” шүлгийн утга дүйлгэц

(Саймон болон Букинагийн хувилбар)

Н.Оюун-Ундраа /МУИС, ГХСС- ГХСТ/

Товч агуулга: Энэхүү өгүүлэлдээ Бэгзийн Явуухулангийн “ Би хаана төрөө вэ?” алдартай шүлгийн эхийг Саймоны англи орчуулга, Букинагийн орос орчуулгатай жишиж тулгасан болно. Уг шүлгийн долоо болон наймдугаар бадгийн орчуулгыг жишсэнээр орчуулгын алдаа оноог дэнслэн, үүний зэрэгцээгээр зарим нэг боломжит өөрийн хувилбарыг санал болгосон байна. Ийнхүү англи, орос орчуулгыг монгол эх шүлэгтэй нь тулгаж задлан шинжилснээр монголоос англи руу орчуулах орчуулгын онолын зарчмын асуудлыг боловсруулах, практик үйл ажиллагааг сайжруулахад бага ч атугай тус дөхөм үзүүлэх зорилготой юм.

Түлхүүр үгс: орчуулгын онол, орчуулгын онолын үзэл баримтлал, үндэсний ахуйн болон сэтгэхүйн онцлог, утга гээгдэх болон гуйвах, орчуулгын найруулгын өнгө аяс, найруулгын өвөрмөц онцлог

Б.Явуухулан амьд сэрүүн цагтаа “...би “Би хаана төрөө вэ?” шүлэгтээ илүү хайртай. Энэ шүлэгт би эх орны тухай, хайрт бүсгүйн тухай бичсэн юм.

Эх орон гэдэг бол: бойжсон өлгий, төрүүлсэн эх, хайрт бүсгүй, үр хүүхэд цөмөөрөө юм.”⁷⁹ гэж хэлсэн байдаг.

Хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн Н.Жамбалсүрэн: “Би хаана төрөө вэ?” гэдэг шүлэг нь чөлөөт орны жаргалтай иргэний бахархах, баясах, бүтээх сэтгэл төрүүлнэ. Үүнийг уншихад хаана ч байж мэдэх ямар нэг сайхан газар биш,... монгол нутаг санаанд ургадаг юм” гэж хэлсэн байдаг⁷⁹.

Ер нь олон судлаач энэ зохиолыг монголын орчин үеийн уянгын яруу найрагт тодорхой алхам болсон гэж үздэг юм байна. Тиймээс ч Болгарын утга зохиол судлаач Цветанка Тафаржийска зохиогчийг нь “Монголын орчин үеийн уянгын яруу найргийн өвөг эцэг”⁸⁰ гэж нэрлэжээ. Эх орны тухай санаа сэдэв сэрэл сэтгэмж нь яруу найрагчийн урлан бүтээх онгодыг байнга урин дууддаг төдийгүй түүний оюун санаа, сэтгэл бодлыг

⁷⁹ “Сэтгэл татах яруу найраг”, “Үнэн”, 1967 оны 7-р сарын 11 №192 10187

⁸⁰ Монголын орчин үеийн яруу найраг, “Гадаадынхан монголын уран зохиолын тухай” номд УБ..1977 319-320 дахь тал

насан туршид баяжуулан авъяас билгийг нь үргэлжид хөгжөөн төгөлдөржүүлсээр байдаг далдын увьдис, хүч чадалтай ажээ.⁸¹

Уран зохиол судлаачид энэ зохиолыг шүлэг, дуулал, найраглал гэхчлэн төрөл зүйлд хамааруулж байна.

Энэ зохиолын зарим бадагт хөгжмийн зохиолч Ж.Шараа ая хийсэн бөгөөд зохиогчид нь БНМАУ-ын Төрийн шагнал олгох тухай тогтоолд энэ зохиолыг нэр цохсон байдаг байна. БНКУ-д хэвлэгдсэн Б.Явуухулангийн шүлгийн түүвэр ч мөн энэ зохиолын нэрээр нэрлэгджээ.

Б.Явуухулангийн дотны найз, ЗСБНХУ-ын социалист хөдөлмөрийн баатар, Төрийн хошой шагналт яруу найрагч А.Сафронов яруу найрагчийн тухай “Баруун Монголд малч ардын гэрт төрсөн болохоор “Хөх манхан тэнгэрийг эзэгнэнхэн төрлөө би” гэж хэлэх бүрэн эрхтэй байсан юм”⁸² гэж хэлсэн байдаг.

Найрагчийн хайртай энэ шүлгийг хуучнаар Зөвлөлтийн яруу найрагч И.Федорины орчуулгаар “Лирика”(1960) түүвэрт анх хэвлэн гаргаж байжээ. Харин дараа нь 1985 онд Л.Букина энэ шүлгийг “Где я родился” нэртэйгээр орчуулан “Из Монгольской Поэзии XX века” номд хэвлүүлэн гаргасан байна.

Хамгийн анх “Би хаана төрөө вэ?” шүлгийг манай нэртэй орчуулагч, толь бичиг зохиогч Д.Алтангэрэл 1986 онд англи хэлнээ орчуулж, “Modern Mongolian Poetry” номдоо хэвлүүлсэн байдаг. Харин 2009 онд Саймон Уикхэм Смит орчуулан “Mongolian verse”, the collected poems of Begziin Yavuuhulan, номдоо хэвлүүлэн гаргажээ. Энэ нь уг шүлгийн англи орчуулгын гурав дахь хувилбар нь болсон байна.

Яруу найрагийн орчуулгын талаар Оросын нэрт зохиолч, гарамгай орчуулагч К.Чуковский “Хувийнхаа туршлагаас бодож үзэхэд миний оролддог уран зохиолын бүхий л төрөл зүйлээс хамгийн төвөгтэй нь шүлэг орчуулах ажил.”⁸³ гэж бичсэн байдаг. Харин орчуулагч, орчуулгын онолч А.Шархүү “Нэг хэлнээс нөгөөд уран зохиол орчуулж байгаа хүн тухайн тэр зохиолд “юуны тухай” өгүүлж байгаа агуулгыг төдийгүй, энэ агуулгаа чухам “яаж”, уран сайхны ямар арга хэрэглүүрээр дамжуулан гаргасныг бас эх хэлээрээ дүрслэн буулгах учиртай. Чухам энэ утгаараа орчуулагч хүн бол орчуулж байгаа зохиолыг хамтран зохиогч нь, тэр зохиолыг бичсэн эзний өрсөлдөгч нь болдог гэж үздэг байна. Ялангуяа яруу найргийн зохиол орчуулах хүнд эх зохиолын агуулга, хэлбэр үзэл санаа, дүр дүрслэлийг нэг ерөнхий цөмд зангидаж өгөх үүрэгтэй, өөр хоорондоо нарийн зохицсон айзам хэмжээ, холбоц, дотоод нугарал, хөг аяс хийгээд,

⁸¹ Ц.Мөнх, “Б.Явуухулангийн яруу найргийн туршлага”, УБ, 1990 он, хуудас 51

⁸² Литературная газета, №9. 3 марта 1982г

⁸³ К. Чуковский. “Высокое искусство”, М.,1964

үг хэллэг санааг нэг бүрчлэн буулгах нэр хүндтэй бөгөөд амаргүй зорилт тулгардаг. ”⁸⁴ гэж бичжээ.

Ер нь яруу найргийг нэг хэлнээс нөгөө хэл рүү буулгахад, ялангуяа эх хэлнээс нөгөө хэл рүү орчуулахад орчуулагч хүн яс хэл зүйн дүрмээр бус, харин түүнээс гажиж бичих найруулгын өвөрмөц онцлогийг ч төрөлх хэлтэн шиг мэдэрч, найруулан бичих олон хувилбар, шадын доторх үг болон нийлэмж үгсийн шилжих хөдөлгөөн, тэдгээрийн байрлал, шүлгийн утгын хэлхээс буюу шүлгийн гол нуруу болох шадын байрлалын бүх л боломжит хувилбарууд болон сэлгэлтэнд ч чөлөөтэй хөвөрч чаддаг байх ёстой болов уу. Үүгээрээ яруу найраг орчуулах найруулгын болон бичлэгийн арга барил нь шулуун шугаманд буюу хэвтээ тэнхлэгт бичигддэг үргэлжилсэн үгийн зохиолын орчуулгаас огт эсрэгээрээ босоо тэнхлэгт байна. Нэг ёсондоо энэ нь орчуулгын онолын үүднээсээ хэл зүйн болон үгсийн сангийн хувиргал бөгөөд үргэлжилсэн үгийн зохиолд огт хэрэглэгддэггүй гэсэн үг биш бөгөөд гагцхүү шүлэг, яруу найргийн орчуулганд илт давуутай хэрэглэгдэж байгаагаараа онцлогтой юм.

Б.Явуухулангийн “Би хаана төрөө вэ”⁸⁵ шүлгийн Саймоны англи орчуулга болон Л.Букинагийн⁸⁶ орос хэл рүү орчуулсан орчуулгыг утга дүйлгэцийн хувьд эх шүлэгтэй нь тулгаж үзье. Гэхдээ эх шүлэг маань арванхоёр бадагтай, бадаг бүр нь таван шадаас бүрдсэн нилээн урт учраас бүх бадагийг тулгаж үзэх боломжгүй тул зөвхөн долоо болон наймдугаар бадагийг харьцуулан авч үзэх болно.

Долдугаар бадаг буюу,

Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би:

Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд,

Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд

Сайхан бүсгүйн сэтгэлийг эзэгнэнхэн төрлөө би. – мөрүүдийг Саймон:

I took my birth in the mind of a beautiful woman,

In the tenderness of her gaze, among her lashes,

In the lapping folds of her deel, reeking of milk.

And, in her modesty, in her thoughts, and in her thoughts,

I took my birth in the mind of a beautiful woman. – буюу

МОНГОЛЧИЛБОЛ:

Сайхан бүсгүйн бодолд би төрлөө,

Сормуусан дундах харцны нь ялдамханд

⁸⁴ А. Шархүү “Үндэстний соёлын ялгаа ба орчуулгын зарим асуудал”, УБ, 2005 он

⁸⁵ Б.Явуухулан “Түүвэр зохиол”, УБ, 1985 он, 387 хуудас

⁸⁶ “Из монгольской поэзии XX века”, М., 1981 он, хуудас 152-154

Сүүний үнэр нэвширсэн (!) дээлийнх нь өвөр хэсгийн нугалаасанд
Түүнийхээ даруухан зан, оюун бодол болон оюун бодолд нь
Сайхан бүсгүйн бодолд би төрлөө, – гэж орчуулсан байна.

Саймон “төрөхийг” зүгээр ч нэг бусдаар үйлдүүлэх хэв буюу Passive Voice-оор үгчилбэл, ‘төрөгдөх’ буюу “*be born*” гэж оноосонгүй, харин “*take one’s birth*” гэж дүйцүүлжээ. Уг хоёр нийлэмж үгсийн хооронд утгын нарийн ялгаа бий. “*Take one’s birth*” гэсэн нийлэмж үгэнд “*be born*” гэсэн нийлэмж үгийг бодвол тухайн газар төрөхөө өөрөө зориудаар сонгож авах гэсэн утга давхар агуулагдаж байна.

Түүнчлэн Саймоны бүх бадгийн орчуулгаас эх шүлэгт байгаа “эзэгнэнхэн” гэдэг үг ор тас гээгджээ. Хэдийгээр ганц л үг боловч гагцхүү ганцхан энэ үг л эх шүлэгт эх орноороо бахархах, эзэн болж төрснөөрөө аархаж омогших сэтгэлийг нэвт шингээж өгч байсан нь орчуулган дээрээ хаягдсанаас болж монгол хүний төрсөн нутгаараа бардамнаж омогших сэтгэл уг шүлгээс бүрмөсөн арчигдсан байна.

“Танцхан үгнээс орчуулгын хувь заяа төдийгүй орчуулагчийн уран бүтээлийн хувь заяа шалтгаалдаг учир ч бий гэж хуучнаар Зөвлөлтийн нэг орчуулагч бчисэн нь түмэн үнэн үг билээ”⁷⁹ гэж нэртэй орчуулагч Ц.Хасбаатар хэлсэн нь маргаангүй үнэн билээ. Мөн үг оноох гэдэг тун нарийн чимхлүүр ажил болох тухайд “Үг гэдэг өөрийн хөг аялгуутай, утга санаатай, уран дүрслэлтэй байдаг учир эх бичгийн чухамхүү тэр хам сэдэвт л таарах цорын ганц үгийг олон шигтгэж өгөх нь орчуулагчийн гол зорилго байдаг.”⁸⁷ гэж манай нэрт орчуулагч, орчуулгын онолч Г.Аким тодорхойлжээ.

Мөн цааш нь тэрвээр “Аливаа зохиолыг орчуулахад дүйлгэх асуудлыг гурван түвшинд авч үзэх хэрэгтэй болдог. Нэгдүгээрт, үг, нийлэмж үгийн түвшинд тохирч байх. Энэ нь үгийн утгыг зөв оноож, найруулгын нь өнгө аясыг тааруулан, уран дүрслэлийг нь тохируулна гэсэн үг юм.....Хоёрдугаарт, өгүүлбэрийн түвшинд тохирч байх. Үүнд гадаад хэлний өгүүлбэрийн утгыг буулгаж, илэрхийлж байгаа өнгө аясыг гаргах нь чухал болно. Ингэхэд өгүүлбэрийн утга нь үлдээд, хэлбэр бүтэц нь өөрчлөгддөг.....Гуравдугаарт, бүхэл зохиолын түвшинд дүйж байх. Энэ нь зохиолчийн номдоо гаргасан санаа, дүр, үзэл санаагаа илэрхийлсэн арга, зохиолчийн өвөрмөц найруулгыг, өөрөөр хэлбэл, уг номын уран сайхныг ягштал буулгасан байх хэрэгтэй гэсэн үг болно.”⁸⁸ гэж хэлсэн нь ч бий.

“Эзэгнэнхэн” гэдэг үгэнд орсон монгол хэлний үйл үгийн –хан, -хэн, -хон, -хөн нөхцөл нь тухайн үйл үгийн бахдах, бахархах, бардамнах өнгө аястай чимхлүүр утгыг илэрхийлдэг. Харин энэ утгын нарийн ялгааг англи хэлэнд хэрхэн буулгах нь нилээн ярвигтай зүйл байж мэдэх ч ор тас боломжгүй зүйл ч бас биш юм. Төрөл хэлний аймгийн хувьд, манай монгол хэл нь алтай хэлний аймагт багтдаг бөгөөд хэл

⁸⁷ Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, УБ., 2009 он, нэмж засварласан хоёр дахь хэвлэл, хуудас 22

⁸⁸ Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, УБ., 2009 он, нэмж засварласан хоёр дахь хэвлэл, хуудас 8

шинжлэлчид монгол хэлийг *agglutinative* буюу залгамал хэл (заримдаа дэлгэмэл хэл ч гэж нэрлэдэг) гэж үздэг бол англи хэл нь Энэтхэг-Европ хэлний аймагт багтдаг, *inflected* буюу дотроо нугалмал хэл юм⁸⁹.

Тэс өөр хоёр хэлний аймагт хамааралтай, хэлний бүтэц байгууллын эрс ялгаатай онцлог шинжээсээ шалтгаалаад англи хэлний үйл үгэнд монгол хэлтэй адил нөхцөл дагавар залгаад тухайн үйл үгийн үгсийн сангийн үндсэн утгаас гадна бахархах бахдах утгын өнгө аясыг хослуулан илэрхийлэх ямар ч арга байхгүй. Гэвч үйл үгийг тодорхойлдог *adverb* буюу дайвар үгтэй хавсарч байж энэ утгыг гаргаж болно. Өөрөөр хэлбэл, эзэгнэх гэдэг үгийг англиар *to reign over*⁹⁰ гэж оноогоод эзэгнэнхэн гэх утгы нь *proudly reigning over* буюу бардаагаар эзэгнэн гэж буулгахад болох мэт санагдана.

Саймон сэтгэл гэдэг үгийг *heart* гэж авсангүй, оюун бодол буюу *mind* болгож орчуулжээ. Харин, *Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд* - гэсэн мөрийг *In the tenderness of her gaze, among her lashes* буюу *Сормуусан дундах харцны нь ялдамханд* гэж англиар гайхамшигтай ончтой бөгөөд уянгалаг, сонсголонтой орчуулсныг зориуд цохон тэмдэглэх хэрэгтэй.

Гэвч гуравдугаар мөр буюу,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд - гэсэн шадыг

Сүүний үнэр нэвширсэн дээлийнх нь өвөр хэсгийн нугалаасанд- гэж орчуулсныг гайхалтай муу орчуулжээ гэж хэлэхээс өөр ямар ч арга алга. Ерөөс энэ шадын төдийгүй бүхэл бадагийн утга, уянгын хөг, өнгө аясыг бүхэлд нь эвдсэн цорын ганц үг бол “ханхлах” гэдэг үгийг орчуулахдаа “нэвшрэх” гэдэг үгийг сонгож авсанд оршино. Энэ нь Саймоны хийсэн хамгийн том алдаа бөгөөд “ханхлах” гэдэг үгийг оноохдоо яагаад ч үл хэрэглэж болох сөрөг өнгө аястай, (сэжиг хүрэм) нэвширэх гэдэг утга бүхий “reek of”⁹¹ гэсэн үйл үгээр оноосон явдал юм. Ийм байж боломгүй, бүдүүлэг алдаа хийснээрээ Саймон манай малчин монголчуудын олон зуун жил малын сүү ууж, түүнийгээ янз бүрийн уламжлалт аргаар боловсруулан, хоол хүнсэндээ идэж хэрэглэж ирсэн зан заншил болон сүүг ариун цагааны бэлэгдэл болгон эрхэмлэн дээдэлж ирсэн монголчуудын сэтгэхүйн онцлогийг огт мэддэггүйгээ илтгэн харуулсан байна. Төрөлх англи хэлтнүүдийн хувьд сүүний үнэрийг ханхлах биш нэвшрэх гэсэн утгаар ярих нь ямар ч гоо сайхны таашаал төрүүлэх нь битгий хэл харин ч бүр гайхан сэжиглэж, цэрвэх таагүй сэтгэгдлийг төрүүлж байна.

Үг оноох талаар орчуулагч, орчуулгын онолч Г.Аким “Үг гэдэг үл үзэгдэх түм буман шижмээр эх хэлнийхээ утга зохиол, соёлын уламжлалтай холбоотой байдаг.

⁸⁹ Google’s, Wikipedia, Free Encyclopedia, History of English Language

⁹⁰ New Oxford Advanced Learner’s Dictionary, 2007, page 1257

⁹¹ Oxford Advanced, 2007 он, хуудас 1269

Тодруулан хэлбэл, үг гэдэг тухайн өгүүлбэр, хэсэг, зохиолтойгоо, цаашилбал, тухайн зохиогчийн бүх уран бүтээлтэй, бүр лавшруулбал, тухайн утга зохиол, тэр ч байтугай тухайн соёл иргэншлийн хүрээтэй холбоотой байдаг”⁹² гэж хэлсэн байдаг.

Харин дөрөвдүгээр мөр буюу,

Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд -гэсэн шадыг

And, in her modesty, in her thoughts, and in her thoughts- буюу монголчилбол:

Түүнийхээ даруухан зан, оюун бодол болон оюун бодолд- гэж үг давтах аргаар утгад хүч нэмэгдүүлэн хувиргаж орчуулсан нь эх шүлгийн утгатай харьцуулахад ядруухан орчуулга болжээ гэж хэлэхэд нэг их хилсдэхгүй биз ээ.

Харин Букина энэ бадгийг,

Я владыкой любви темноглазой монголки родился,

Мягкий терлик вокруг ее тонкого стана обвился,*

Робкий взгляд ее светится мне сквозь ресницы,-

Ласк горячих и нежных наивная юность стыдится.

Да, владыкою сердца монголки на свет я родился!— буюу монголчилбол:

Хар нүдэн монгол бүсгүйн хайрыг эзэгнэгч болж би төрлөө

Зөөлөн тэрлэг нь туяхан гоолиг биеий нь барина

Сормуусан дундах аймхай нүд нь надад гэрэлтэнэ

Халуухан болоод энхрийхэн энхрийлэлтэнд гэнэн залуу нас ичингүйрнэ

Тиймээ, Монгол бүсгүйн зүрх сэтгэлийг эзэгнэгч болж энэ хорвоод би төрлөө— гэсэн байна. Саймоныг бодвол Букинагийн орчуулгад “эзэгнэнхэн” гэдэг үгийг яг тэр утгаар нь “владыкой”⁹³ гэж орчуулсан нь тун ончтой болжээ. “Зохиолын уран үг хэлний асуудалд үгсийн сангийн онцгой үгс, утга шилжүүлэх ёс зэргээс гадна үргэлжилсэн үгийн болон яруу найргийн зохиол аль нь ч хэл зүйн хууль дүрмийн дагуу хэрэглэхээс өөр маягаар зохиолыг улам уран яруу болгохын үүднээс зориуд оруулан ашигладаг өгүүлбэр зүйн уран маяг (синтаксические фигуры) гэж байдаг. Өгүүлбэр зүйн олон уран маягт зүйл бүрийн давтах маяг орно... өгүүлбэр юмуу шадын эхийг сүүлд нь давтах бөгжин давтал (кольцо) гэж байдаг”⁹⁴ байна.

Эх шүлэгт эхний мөрүүд бадгийн сүүлд давтагддаг буюу бөгжин давталттай бол Букина орчуулгандаа бадгийн сүүлийн давталтыг зүгээр нэг байгаа чигээр нь давтах биш, нилээн хүч нэмэгдүүлсэн утга оруулж, өгүүлбэрийн гишүүдийг тонгоруу маягаар байршуулан, найруулгын өвөрмөц онцлогтойгоор бичсэн нь маш оновчтой болсныг онцолж хэлэх хэрэгтэй болов уу. Саймон ч бас сүүлчийн мөрөөр бөгжин давталт

⁹² Г.Аким, “Орчуулгын санг уудлахад”, УБ, 1984 он, хуудас 23

⁹³ Russian-English Dictionary, М., 1965 он, хуудас 78

⁹⁴ С.Дулам, Ц.Хасбаатар, “Уран зохиолын онолын үүд”, УБ, 1980 он, хуудас 163

хийхдээ Букина шиг ийм найруулгын өвөрмөц онцлогтойгоор англи хэл рүү буулгаж бүрнээ болох байсан.

Мөн Букина энэ орчуулгадаа “сайхан бүсгүйг” хар нүдэн монгол бүсгүй болгон өөрчилж, эх шүлгийн хоёр болон гуравдугаар мөрийн байрыг орчуулган дээрээ сэлгэн, утгын хувьд ч мөн их л өөрөөр дүрсэлсэн байна.

Өөрөөр хэлбэл,

Сормосон дундаа талимаарах алаг нүдний мэлмэрээнд- гэсэн мөр нь

Сормуусан дундах аймхай нүд нь надад гэрэлтэнэ- болж хувирч,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд- гэсэн мөрийг

Зөөлөн тэрлэг нь туяхан гоолиг биеийг нь барина- гэж утгын хувьд эх шүлгийн утгаас ихэд өөрчлөн бичсэн боловч зарим талаараа, ялангуяа эх шүлгийн хоёрдугаар мөрний утгыг гуравдугаар мөрөн дээр ямартаа ч нүдний тухай өгүүлэхдээ огт өөр дүрслэлээр боловч үүргээр дүйцүүлэн орчуулсан байна гэж хэлж болохоор байна. Үүргийн хувьд дүйлгэх үзэл баримтлал нь (концепция функциональной эквивалентности) тухайн орчуулга дүйж байна уу үгүй юу гэдгийг эх орчуулга хоёрыг харьцуулж бус орчуулгыг уншигч, эх бичгийг уншигч хоёрын сэтгэгдлийг харьцуулахыг санал болгодог байна.⁹⁵ Хэрвээ сэтгэгдэл нь адил байвал орчуулгыг эх бичигтэйгээ дүйхээр болжээ гэж үзэх хэрэгтэй ажээ.

Харин эх шүлгийн гуравдугаар мөр буюу,

Саалийн үнэр ханхалсан дээлийн хормойн нугалаасанд- гэсэн мөрийг үндсээр нь өөрчлөн бүсгүйн гоолиг биеийн дүрслэл болгон хувиргахдаа дээлийг “тэрлэг” болгож тухайн мөрийн утгыг нарийвчлан гаргахыг оролджээ.

Мөн дөрөвдүгээр мөр буюу,

Санан санан уярах цэвэр ичимтгий аашинд - гэсэн мөрийг

Халуухан болоод энхрийхэн энхрийлэлтэд гэнэн залуу нас ичингүйрнэ - гэж эхээс огт өөр маягаар дүрсэлсэн боловч ямартаа ч ичингүйрлийн тухай санаа хадгалагдаж үлдсэн байна. Тэрлэг гэдэг үгийг “терлик” буюу галигчлан буулгаж оруулаад ямар нэгэн зүүлт тайлбарыг оруулж бичээгүй байна. Терлик гэж галигласан үгийг С.И Ожеговын толь бичгээс харахад ийм үг огт байхгүй байна. Эх шүлгийн утгатай хамгийн сайн дүйж байгаа мөр нь энэ бадагт хамгийн сүүлчийн мөр л байна. Гэхдээ эх шүлэгт байгаа бүсгүйн “сайхан” гэдэг утга нь гээгдэн, монгол бүсгүй болж өөрчлөгдсөн байна.

Наймдугаар бадаг буюу,

Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би:

Тэлмэн жороо морины шанхны үзүүрийн чичиргээнд,

Тэнгэрийн салхинаас бусдыг дээрээ гаргаж үзээгүй

Тэнгэр говийн сүрэг онгон хулангийн нуруунд

Тэнхээт хүлгийн дөрөөг эзэгнэнхэн төрлөө би. – гэсэн мөрийг англи хэл рүү

Саймон: *I took my birth in the stirrups of a mighty riding-horse,*

⁹⁵ Г.Аким, Орчуулгын санг уудлахад, 1984 он, хуудас 11

*In the twitching forelock of an old ambler,
Seeing nothing more than the wind in the sky,
And, upon the smooth back of an ass, from a desert herd,
I took my birth in the stirrups of a mighty riding-horse.—* гэж буулгажээ.

Хэрвээ эдгээр мөрийг утгаар нь монголчилбол:

*Хүчирхэг хүлгийн дөрөөнд би төрлөө,
Хөгшин жороо морины шанхны чичиргээнд
Тэнгэрийн салхинаас бусдыг огт үзээгүй
Цөлийн сүрэг болох илжигний тэгшихэн нуруун дээр*

Хүчирхэг хүлгийн дөрөөнд би төрлөө— гэсэн үг юм. Эх шүлгийн хоёрдугаар мөрөнд байгаа “тэлмэн жороо” гэсэн хоршоо үгийг “хөгшин” жороо морь гэж орчуулсан байна. Орчуулагч яагаад ч юм тэлмэн гэдэг үгийг хөгшин гэж ойлгосон бололтой юм. Энэ үгийг Bawden-ын толь бичгээс сийрүүлэн харвал (усан) тэлмэн жороо буюу true ambler⁹⁶ гэж оноожээ. Тэлмэн гэдэг үгийг “Монгол хэлний хэл зүйн тайлбар толь”-ноос харахад үг нь байгаа боловч тайлбар хийгдээгүй байна. Ер нь бол энэ үг нь зөөлөн гэсэн утгатай аж. Тиймээс англиар gently ambling steed буюу зөөлөн жороолдог хүлэг гэж нийлэмж үгсээр орчуулбал утга нь илүү сайн гарч өгөх байсан болов уу.

